



ШИНЭ  **МОНГОЛ** 
ESTD 2000
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ

Дунд, Ахлах ангийн сурагчид болон эцэ гэхчүүдэд зориулсан

Гарын авлага 2026-2027



www.shinemongol3.edu.mn
hello@shinemongol3.edu.mn

Агуулга

| | |
|--|-------|
| Захирлын мэндчилгээ | 1 |
| Шинэ Монголын үзэлсанаа | 2 |
| ШинэМонгол-3 сургуулийн 5Б үнэт зүйлс | 3 |
| Төгсөгчийн загвар | 4 |
| Хөтөлбөрийн онцлог | 5 |
| Арга зүйн онцлог | 6 |
| Дугуйлан секцүүд | 7 |
| Сурагчдын өөртөө удирдах зөвлөл-СӨҮЗ | 8 |
| Сургуулийн автобусны мэдээлэл | 9 |
| Хичээлийн шинэ жилд бэлтгэх зөвлөмж | 10-11 |
| Зуны амралтаар юуг сурч ирэх вэ? | 12 |
| Дүрэмт хувцас | 13-14 |
| Эрүүл хооллолтын бодлого, өдрийн хоолны мэдээлэл | 15 |
| Цахим хэрэглээний журам | 16 |
| Эцэгэх, асран хамгаалагчийн оролцоо | 17 |

Шинэ Монгол 3 сургуульд тавтай морил



Хүндэт эцэг эх, асран хамгаалагчдаа

Та бүхэн гэр бүлийнхээ хамгаас үнэт эрдэнэ болсон хүүхдээ бидэнд итгэн даатгаж, Шинэ Монгол 3 сургуулийг сонгосонд гүн талархал илэрхийлье.

Манай сургууль хүүхэд бүрийг өөрийн гэсэн авьяас, онцлогтой, хөгжлийн өвөрмөц замтай хувь хүн гэж үздэг. Тийм ч учраас хүүхэд бүрт тэрхүү үрээ нээн илрүүлэхэд нь зориулж урам зориг, эрэл хайгуул дүүрэн орчинг бүрдүүлэн, өөрийнхөөрөө суралцаж, хөгжихөд нь бүх талаар дэмжсэн соёлыг бүтээхийг зорьж байна. Бид сурагчдыг зөвхөн академик мэдлэгтэй төдийгүй, өөрийн бие сэтгэл болон бусдыг ойлгох ухаантай, сэтгэл зүйн хувьд тогтвортой, ёс зүйтэй, энэрэнгүй, хариуцлагатай, нийгмийн идэвхтэй, хэрсүү, зоригтой, бүтээгч иргэн болж төлөвшихөд нь дэмжиж, чиглүүлэн ажиллана.




“Шинэ Монгол” сургуулийн гурав дахь салбарын хувьд бид зөвхөн барилга байгууламжаараа бус, орчин үеийн боловсролын үзэл баримтлал, хүүхдийн хөгжилд хандсан шинэ санаачилгаар ч шинэлэг байхыг зорьж байна.

Энэхүү зорилгын хүрээнд бид хөтөлбөрөө хүүхдийн сонирхлыг өдөөн хөгжүүлэх, бүтээлчээр сэтгэх, бие даан суралцах, шийдвэр гаргах чадварт төвлөрүүлж боловсруулсан бөгөөд эцэг эх, асран хамгаалагчдад хамгийн боломжит бага зардлаар хүргэхийг хичээн ажиллаж байна.

Хөршийн холбоонд суурилан амьдралын эрүүл боловсон хэв маяг, найрсаг харилцаагаар дамжуулан та бид бүгд тасралтгүй хөгжих энэхүү замыг хамтдаа эхлүүлж буйдаа бид туйлын баяртай байна.

Та бүхний итгэл, оролцоо бидний хамгийн үнэтэй түншлэл юм.

Хүндэтгэсэн,
Галбадрахын СУУРЬ, PhD
Захирал



Үзэл санаа
Алсын хараа
Эрхэм зорилго
Үнэт зүйлс

Шинэ Монголын ҮЗЭЛ САНАА

Бид “Шинэ Монгол” сургууль, “Шинэ Монголчууд” нэрээр овоглосон Монгол Улсынхаа ирээдүйг үүрэлцэж, дотоод гадаадад түүчээлж буй өндөр чадвартай, итгэл даах хүн бүрийн зүрхэнд шингэсэн үзэл санааг “Шинэ Монгол 3” сургуульдаа өвлөн уламжилж байна.

Монгол, япон олон хүний өгөөмөр тусламж, хичээл зүтгэлийн дүнд 2000 онд байгуулагдсан сургуулийнхаа эхэлсэн цаг, туулсан түүхийг шинэ монголчууд бид үеийн үед бахархан өчсү.

- Бусдад туслах, талархах сэтгэлээс аз жаргал үүддэгийг санаж, өрөөлд аз жаргал бэлэглэн, өөрийн аз жаргалыг дархалж явсу.

- Дэлхийд үнэлэгдэх монгол иргэн болж төлөвшихийн тулд зүрх сэтгэл, оюун ухаан, бие бялдраа дайчлан өөрийгөө хөгжүүлсү.

- Агуу түүх бүтээсэн эцэг өвгөд, амжилтын эзэд болсон номын ахан дүүсээ дээдэлж, шударга ёс, хүн байгалийн шүтэн барилдлага, хүмүүн төрөлхтөний эв нэгдэл, энхтайвныг эрхэмлэсэн Монгол улсыг цогцлоосу.

Шинэ Монгол 3 бидний

АЛСЫН ХАРАА

“Монгол хүүхдийн амин чанарыг аз жаргалаар тэтгэн хөгжүүлдэг тасралтгүй суралцах жишиг сургууль байна.”

ЭРХЭМ ЗОРИЛГО

“Өөрийгөө таньж өрөөлд үлгэрлэх хэрсүү зоригтой, шинэ үнэцэнийг бүтээгч эрдэмтэн иргэдийг бэлтгэхийг зорьж ажиллана.”

Шинэ Монгол-3

сургуулийн **5Б** ҮНЭТ ЗҮЙЛС

Бид алсын хараа, эрхэм зорилгоо өдөр тутамдаа марталгүйгээр, үг, үйлдэл, шийдвэр бүртээ санаж явахын тулд дараах үнэт зүйлсэд тулгуурласан байгууллагын дадал соёлыгбий болгохыг зорьжажиллана.

Эдгээрийг багш ажилтнууд, хүүхдүүд, эцэг эх асран хамгаалагчид, цаашлаад хотхоны оршин суугчид маань эн тэнцүү ойлгодог, хүндэтгэдэг, баримталдаг болсноор бид нэгдсэн зорилго руугаа чиглэн урагшилж чадах юм.

01 БҮРЭН ТӨЛӨВШИХҮЙ

- **Өөриймсөг хандах:**Аливаад эзэн сэтгэлээр, ухамсар хариуцлагатай
- **Өөрийгөө удирдах:** Сэтгэл хөдлөлөө удирддаг, сэтгэлийн хаттай, тууштай, эрүүл амьдралын дадалд суралцсан
- **Өөрийн нөөц өгөгдлийг тэтгэх:** Өөрт заяасан өгөгдөл, авьяас, урчадвар, оюун ухаан,зан чанараа танин мэдэж, хөгжүүлэн төлөвшинө.

02 БАЙНГЫН СУРАЛЦАХҮЙ

- **Шинэчлэх ухаан:**Аливаад эргэлзэх, асуулт тавьж, шимтэн сониучирхаж, өөр өнцгөөс харах
- **Шинжлэх ухаан:** Сонирхсоноо гүнзгийрүүлэн судлах, мэдлэгээ тэлж туршлага хуримтлуулах
- **Шийдэх ухаан:** Бодит амьдралд мэдлэгээ хэрэгжүүлэх, туршлагаа ухаарал болгон хувиргах

03 БУСДАД ҮЛГЭРЛЭХҮЙ

- **Хариуцлагатай:**Зөвбуруугялган, өөрийн үйлдэлд эзэн болох хариуцлагатай
- **Хүнлэг:** Хүнийг ойлгох, анхаарах, халамжлах сэтгэлтэй
- **Хүндлэлхүлээсэн:** Хэрсүүзоригтой, нийтэд хүлээн зөвшөөрөгдөн итгэл олсон

04 БҮГДЭД ЗОХИРОХҮЙ

- **Ээлтэй:** Өөртөө, бусдад болон байгальдаа ээлтэй
- **Эвтэй:**Бүх харилцаанд хүндэтгэлтэй, эвтэй
- **Эерэг:**Бусдадталархалтай, эерэг хандлагатай
-

05 БҮГД ХҮРТЭХҮЙ

- **Ил тод байдал:** Бүхий л мэдээлэл, шийдвэр, үйл явц ил тод, итгэлцэл дээр суурилсан
- **Ижил тэгш байдал:** Хэнийг ч гарал үүсэл, нөхцөл байдал харгалзахгүйгээр тэгш хүндэлж, харилцах
- **Идэвх:** Хүн бүрийн дуу хоолойг сонсож, идэвх оролцоог дэмжих



Төгсөгчийн загвар

“Тэр зөвхөн сайн сурсан биш, сайн нийгмийг бүтээдэг иргэн юм.”

Бид таны хүүхдийн дахин давтагдашгүй онцлогийг хүлээн зөвшөөрч, сурч хөгжих онцлогт тохирсон арга барилыг ашиглахыг зорино. Харин хэзээд өөрийн замыг зөв чиглүүлж, өөрийнхөөрөө гэрэлтэн утга учиртай амьдрахад дараах шинж чанаруудыг бид чухал хэмээн итгэдэг тул Шинэ Монгол-3 сургуулийн төгсөгчид дараах шинж чанараар ижилсэх болно.



ХҮНЛЭГ
COMPASSIONATE



ЁС ЗҮЙТЭЙ
ETHICAL



ЗОРИГТОЙ
COURAGEOUS



СОНИУЧ
CURIOUS



ШҮҮН ТУНГААДАГ
INQUIRER



БҮТЭЭГЧ
CREATOR




Бусдыг ойлгож, халуун сэтгэлээр ханддаг **ХҮНЛЭГ**, ямагт зөвийг эрхэмлэгч, шийдвэр бүртээ хариуцлагатай **ЁС ЗҮЙТЭЙ**, хэзээд суралцахыг сонгодог, тасралтгүй суралцагч сониуч зантай эрсдлээс айж хувийн амрыг хардаггүй.

Шинийг эхлүүлэхээс айдаггүй хэрсүү **ЗОРИГТОЙ** өөрийнхөөрөө гэрэлтэж, бусдад эергээр нөлөөлөхүйд бэлэн, зорьсон сургуульдаа ч зорьсон ажилдаа ч **БЭЛТГЭГДСЭН**, мөрөөдлөө бодит болгох чадвартай, шинэ үнэ цэнийг **БҮТЭЭГЧ** байна.



Хөтөлбөр & Аргазүйн онцлог

- ❑ ХӨТӨЛБӨРИЙН ОНЦЛОГ
 - ❑ АРГА ЗҮЙН ОНЦЛОГ
 - ❑ ДУГУЙЛАН, СЕКЦ, ЗӨВЛӨЛҮҮД
- 

Хөтөлбөрийн ОНЦЛОГ



- Хүүхэд бүрийн сурах онцлогт тохирсон "ХҮҮХЭД ТӨВТЭЙ" сургалтын арга зүй.
- Бие даан суралцах арга зүйгээр тасралтгүй суралцахуйг дэмжих.
- Суралцагч бүр өөрийн сонирхолд тулгуурлан 1 зөвлөл, дугуйланд сонгон суралцах боломж.
- Нас, сэтгэлзүйн онцлогт тохирсон амьдрах чадварын хөтөлбөрүүд.



- Үеэр суралцах сургалтын хэлбэр.
- Ангийн суралцагчдыг сэлгэн хуваарилах арга зүй
- Бага сургуулиас---Дунд сургууль---Ахлах сургуульд элсэхдээ элсэлтийн шалгалт өгч, тэнцсэн тохиолдолд элсүүлэн суралцуулна.

Манай сургуулийн онцлох хөтөлбөрүүд:



Эх хэл ба гадаад хэлний бодлого



Амьдрах чадварын хөтөлбөр



Япон болон Хятад хэлний хөтөлбөр



Илэрхийлэх ур чадварын хөтөлбөр



Мэргэжил сонголтын хөтөлбөр



Сии хөтөлбөр

Аргазүйн ОНЦЛОГ

“Хүүхэд төвтэй” арга зүй

01 Судлаач багш

Хичээл, үйл ажиллагааг төлөвлөхдөө багш өөрийн зүгээс үйлээ төлөвлөж эхлэх бус, харин хүүхдийн мэдлэг ямар байгаа гэдгийг тандаж, дэс дараалал болон агуулгаа төлөвлөдөг байна. Аливаа зүйлийг ажиглан судлаж, дүгнэлт хийх чадвар эзэмшихэд чиглэсэн чөлөөт судалгааг хүүхэд бүр хийнэ.

03 Зорилготой суралцагч

Бид сурагч бүрийг өөрийнх нь тавьсан зорилго, хүсэл мөрөөдлөөр нь чиглүүлдэг байна. Хичээлийн шинэ жилд хүүхэд нэг бүрийн, ангийн, үеийн, сургуулийн түвшинд зорилго тодорхойлох, түүн рүү нь хөтлөн чиглүүлдэг байна. Хийх үйлдлийг бус зорилго буюу хүрэх замыг чиглүүлдэг багш хамт олон байна.

05 Оролцоог дэмждэг багш

Бид сургуулийн үйл ажиллагаанд хүүхдийн оролцоог боломжит хамгийн өндөр түвшинд байлгах ба үүнийг гүйцэтгэх нэг зам нь “Сурагчийн өөрөө удирдах зөвлөл”-үүдтэй байх явдал юм (дараагийн хуудсанд дэлгэрэнгүй буй). Үүгээр дамжуулан хүүхдүүд мэргэжил, ажил үүргийн чиг баримжааг эзэмшинэ.

02 Чиглүүлэгч багш

Багш нь хүүхдийн хийх үйл, хэлэх үгийг өөрт нь үлдээж чаддаг байна. Багш бүр өөрийн оролцоог гуравдагч байр сууриас харж, төсөөлж, оролцоогоо хянаж чаддаг байна. Хүүхдийн хийж чадах зүйл, хэлэх чадвартай үгийг тэвчээртэйгээр хүлээн өөрөөр нь хэлүүлдэг, түүнийг дэмждэг чиглүүлэгч байх.

04 Өөрийн удирдлагатай суралцдаг суралцагч

Сурагч өөрөө юу сурах вэ гэдгээ шийдэж, сурах зорилгоо тодорхойлж, цагийн менежмент хийж, өөрт тохирсон арга барилыг сонгож, сурах явцдаа өөрийгөө хянаж, засаж, амжилт, алдаагаа эргэцүүлэн дүгнэх чадварт суралцана. Энэ нь хүүхдийн хариуцлага, өөртөө итгэх итгэл, сэтгэлгээний уян хатан байдал, асуудал шийдэх чадварыг хөгжүүлдэг маш чухал чадвар билээ.

06 Хэрэгцээнд нийцсэн сургалт

Хүүхдийн насны онцлог бүрт өөрийн гэсэн хэрэгцээнүүд байдаг ба өөрөөр хэлбэл хөдөлгөөний хэрэгцээ, сонирхон гүнзгийрүүлэн судлах хэрэгцээ, өөр рүүгээ өнгийж харж, өөрийгөө таних хэрэгцээ зэргийг хангадаг байхад анхаарах болно.

Дугуйлан, секц

Шинэ Монгол сургуулийн нэгэн том соёл бол хүүхэд бүрт хүртээмжтэй дугуйлан секцийн хөтөлбөр юм. Бид хүүхдүүддээ өөрийгөө нээх, өөрийн авьяас чадвар, сонирхлоо турших, сорих олон талбарыг бий болгохын тулд багасургуулийн 2 дугаар ангиас эхлэн ямар нэг нэмэлт төлбөргүйгээр дугуйлан, секц бүрээс тус бүр нэгийг сонгож хичээллэх боломжийг бий болгож байна.

Бид урлаг, спорт, шинжлэх ухаан, техник, нийгмийн чиглэлийн төрөл бүрийн секц дугуйлангаар дамжуулан хүүхдийн авьяас чадварыг эрт нээхийг зорих ба жил бүр хүүхдүүдийн дунд судалгаа явуулж эрэлт хэрэгцээнд үндэслэн ангийн тоо, багтаамж, төрөлд зохих өөрчлөлт оруулж байх болно.

Дугуйлан секцэд багаасаа тогтмол хамрагдахыг дадал болгох нь хүүхдэд тухайн талбарт хөгжихийн зэрэгцээ бусадтай хамтран ажиллах, манлайлах, тууштай байх, тэвчээр хатуужилтай болох, өөрийгөө дайчлах, цагаа зөв удирдан зохион байгуулах, тэмцээн тоглолтод бэлтгэх, ялж ялагдаж сурах зэрэг олон сайн зан чанаруудыг төлөвшүүлэн хүмүүжүүлдэг тул эцэг эх асран хамгаалагчид дугуйлан секцийн сонголт, явц, тайлан зэрэгт анхаарал хандуулан, урам зориг дэмжлэг өгөх байдлаар ач холбогдол өгч хамтран ажиллахыг уриалж байна.

01 Дугуйлан

- Гитар
- Төгөлдөр хуур
- Моринхуур, шанз, ятга, ёочин, хуучир
- Зураг
- Гар урлал
- Бяцхан судлаач
- Program coding
- Robokids
- IELTS

02 Секц

- Сагс
- Воллейбол
- Хөл бөмбөг
- Ширээний теннис
- Шатар
- Спортын гимнастик
- Бадминтон
- Карате



Сурагчдын зөвлөл-СӨУЗ

Шинэ Монгол 3 сургуулийн хувьд сурагчдын зөвлөлтэй байх бөгөөд анги бүрээс зөвлөл болгонд 1-3 сурагч хамрагдана. 6-11-р ангийн суралцагчид нэг зөвлөлийн үйл ажиллагааг хамтран удирдан зохион байгуулна.

Хамгийн ахмад анги буюу 11-р ангийн сурагчид удирдан чиглүүлнэ. Тухай бүрийн чиглэлээр сурагчид сургууль доторх аливаа үйл ажиллагааг өөрсдөө төлөвлөж, сурагчдын төлөвлөсөн үйл ажиллагаа сургууль дээр хэрэгжинэ.

Зөвлөл нь хүүхдийг бусадтай хамтрах, мэргэжлийн чиг баримжаагаа өөрөө тогтоох зэрэг бодит туршлага хуримтлуулах хамгийн амьдралд ойрхон практик болж чаддагийг Япон сургуулиудын туршлагаас харж болдог. Бид сурагчид аливаа туршлагыг сургууль дээрээ хуримтлуулж, өөрийгөө нээн таних боломжийг олгохын тулд сурагчдын зөвлөлийг сургууль нийтээрээ, хүүхэд бүрийг заавал хамруулах хэлбэрээр хэрэгжүүлнэ.


Зөвлөлүүд:

- Ангийн дарга нарын зөвлөл
- Номын сангийн зөвлөл
- Эрүүл мэндийн зөвлөл
- Сургуулийн орчны зөвлөл
- Эрүүл хооллолтын зөвлөл
- IT технологийн зөвлөл
- Эко зөвлөл
- Соёлын зөвлөл
- Хэвлэл мэдээллийн зөвлөл
- СИИ хөтөлбөр хариуцсан зөвлөл



Өдрийн хуваарь & Сургуулийн автобус

ХИЧЭЭЛЛЭХ ЦАГИЙН ХУВААРЬ
АВТОБУСНЫ МАРШРУТ



ШинэМонгол-3 сургууль нь тогтмол, тогтвортой үйл ажиллагаа болон зохионбайгуулалт сайтай орчин нь хүүхдүүдийн хөгжлийн үндэс гэж үздэг. Бид өдрийн хөтөлбөрөө бүтэцлэхдээ зохион байгуулалттай суралцах үйл ажиллагаа, чөлөөт тоглох цаг, амралт болон судлан шинжлэх боломжуудыг тэнцвэртэй хослуулахыг зорьсон. Ингэснээр хүүхэд бүрийн бага насны сургуулийн амьдрал хамгийн үр дүнтэй, дурсамжтай, баялаг болох боломж бүрдэнэ гэж үзэж байна.

Өдрийн хуваарийн ерөнхий төлөвлөгөө (Жишээ)

| № | Цаг | Үйл ажиллагаа | Тайлбар |
|----|---------------|--|------------------------------------|
| 1 | 7:30 - 7:40 | Сургуульдаа ирэх | Сургуулийн үүд 7:00 цагт нээгдэнэ. |
| 2 | 7:50 - 8:00 | Ангийн цаг | - |
| 3 | 8:00 - 8:40 | Хичээлийн цаг № 1 | - |
| 4 | 8:45 - 9:25 | Хичээлийн цаг № 2 | - |
| 5 | 9:25 - 9:40 | Дасгалын цаг | - |
| 6 | 9:45 - 10:25 | Хичээлийн цаг № 3 | - |
| 7 | 10:30 - 11:10 | Хичээлийн цаг № 4 | - |
| 8 | 11:15 - 11:55 | Хичээлийн цаг № 5 | - |
| 9 | 12:00 - 12:40 | Их завсарлагаа (Үдийн хоол) | |
| 10 | 12:45 - 13:25 | Хичээлийн цаг № 6 | - |
| 11 | 13:30 - 14:10 | Хичээлийн цаг №7 | - |
| 12 | 14:15 - 14:55 | Хичээлийн цаг №8 | - |
| 13 | 15:00-15:40 | Хөгжүүлэх/ бие даан суралцах цаг | Зөвхөн 6-11-р ангиуд |
| 14 | 15:45-16:25 | Хөгжүүлэх/ бие даан суралцах цаг | Зөвхөн 6-11-р ангиуд |
| 15 | 16:30 | Хичээл сургалтын үйл ажиллагаа дуусна. | |




Сургуулийн автобус

Маршрутын мэдээлэл
(2025-2026 оныхичээлийнжилийнжишээ):

1. ШМЗ-Яармаг-Зайсан
2. ШМЗ-Нүхт
3. ШМЗ-Яармаг-120 мянгат-Баянмонгол хороолол
(хүүхдийн тооноос хамаарна)
4. ШМЗ-Яармаг-Гурвалжингийн гүүр-3,4 хороолол-Хангай хотхон хавийнбүс (хүүхдийн тооноосхамаарна)
5. ШМЗ-Сонсголон-1-р хороолол-Саппоро



Сургуулийн автобусны маршрут тухайн жилийн сурагчдын автобусны судалгаанд үндэслэн гаргана. Автобусын үйлчилгээнд хамрагдах судалгаа, төлбөрийн мэдээллийг 8-р сард илгээх болно.



Хичээлийн шинэ жилд бэлтгэх зөвлөмж

- ❑ Сэтгэл зүйн бэлтгэл
- ❑ Сурч ирэх дадал
- ❑ Дүрэмт хувцас, хичээлийн хэрэгсэл



Шинэ сургуульд дасан зохицох шилжилтийн үеийг амжилттай даван туулахад эцэг эх, асран хамгаалагчийн таны зүгээс мэдэж байвал тустай мэдээллийг бэлтгэн хүргэж байна.

Хүүхдийн дасанзохицох шаардлагатай орчин

Хүүхэд шинэ сургуульд орохдоо хэдий чинээ хурдан дасаж чадах нь тэднийг амжилттай суралцахад төдий чинээ нөлөө үзүүлдэг. Хүүхэд өөр сургуульд элсэн суралцахад маш олон зүйлтэй дасан зохицох шаардлагатай болдог байна. Тухайлбал:

1. Сургууль, ангийн орчин
2. Багш нарын харилцаа
3. Ангийн найз нөхдийн харилцаа
4. Сургууль, ангийн дүрэм журам
5. Хичээлийн зохион байгуулалт, цагийн хуваарь
6. Ном, сурах бичиг, хичээлийн хэрэгсэл
7. Сурах арга барил
8. Амьдралын шинэ хэмнэл, өдрийн дэглэм зэрэг

Хүүхдийн нийгмийн харилцаанд үүсэх өөрчлөлтүүд

Хүүхэд сургуулийн орчин, сурах үйлд дадаж суралцаагүйгээс амархан ядрах, бусадтайгаа харилцаж чадахгүй байх, самбарын өмнө гарч асуултад хариулахаас ичих, айх, сурлагаар хоцрох, улмаар сургуульд суралцах хүсэл сонирхолгүй болох зэрэг бэрхшээл үүсэх боломжтой байдаг.

- | | | |
|-----------|---------------------------------|--|
| 01 | Эцэг эхийн харилцаа | Шинэ сургуульд элсэн орсноор гэр бүлийн гишүүн бүр илүү нээлттэй ярилцаж, шинэ орчинд дасан зохицох хугацаанд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх. |
| 02 | Хүүхэд багшийн харилцаа | Шинэ багш нартай танилцах, харилцан ойлголцох, хамтран ажиллах шаардлага үүсэх тул илүү нээлттэй мэдрэмжээ чөлөөтэй илэрхийлэх нь чухал. |
| 03 | Үе тэнгийнхэний харилцаа | Үе тэнгийнхэнтэйгээ нээлттэй харилцах, бусдыг байгаагаар нь хүлээн зөвшөөрөх, бусдын ялгаатай байдлыг хүндлэх, хамтран хөгжих боломжтой орчныг бүрдүүлэхэд суралцагч, багш, эцэг эх хамтран ажиллах. |

Иймд шинэ сургуульд орох хүүхэдтэйгээ бид сайтар ярилцан сонсож, ойлгон, сэтгэл санаа, эрүүл мэнд, бие хүний төлөвшлийн хувьд бэлтгэх нь чухал юм.

Шинэ сургуульд орох гэж байгаа хүүхдийн юуг анхаарах вэ?



1 Сэтгэл зүйн дасан зохицлыг дэмжих

- Хүүхэдтэй хамт сэтгэл хөдлөлөө хуваалцаж, өөрийгөө илэрхийлэх орчинг бүрдүүлэх
- Хүүхдийн айдас, түгшүүрийг үгүйсгэлгүйгээр хүлээн зөвшөөрөх
- Шинэ сургуулийн орчин, дүрэм, багш нарын тухай урьдчилантанилцуулах
- Сургуулийн вэбсайт, зураг, видеогоор дамжуулан орчны төсөөлөл өгөх

Яагаад чухал вэ? - Тодорхойгүй байдал нь хүүхдийн айдас, түгшүүрийг нэмэгдүүлдэг.



2 Эцэг эхийн дэмжлэг, итгэлтэй харилцааг бий болгох

- “Чи чадна” гэх итгэлтэй үгс, дэмжих үйлдэл нь маш их нөлөөтэй.
- Хэт өндөр хүлээлт тавихгүй байх “Бүгдийг хамгийн сайн хий” биш, “Чадах чинээгээрээ хичээгээрэй” гэдэг уриатай байх.
- Өдөр бүрийн сэтгэгдлийг сонсож, ойлгож, хамт бодож, шийддэг байх.
- Өөрийгөө танилцуулах, багаар ажиллах ур чадвар /хүндэлсэн харилцааг зааж өгөх/

Яагаад чухал вэ? - Хүүхэд бусадтай харилцахад өөртөө итгэлтэй, сэтгэл хангалуун байхад эцэг эхийн дэмжлэг чухал



3 Өсвөр насны хүүхдүүдийн нийгэмшлийн онцлог

- Найз нөхөд маш чухал байр суурьтай болно. Ямар нэг бүлэгт багтах эрмэлзэл нэмэгдэнэ.
- Багш, эцэг эхээс илүү найз нөхдийн нөлөө давамгайлах хандлагатай.
- Бусдын сэтгэл ханамж, үнэлэмжийг хайдаг, хүлээн зөвшөөрөгдөхийг хүсдэг.
- Хувийн орон зай, нууцлал чухал болдог.
- Хувийн зүйлд халдахыг эсэргүүцдэг.
- Сонирхлын бүлгүүдэд нэгдэх, дүрэм журамтай харьцах чадвар төлөвшдөг.



4 Өсвөр насны хүүхдүүдийн сэтгэл зүйн онцлог

- Бие даах хүсэл, өөрийн гэсэн байр суурьтай болох эрмэлзэл нэмэгдэнэ.
- Сэтгэл санааны хэлбэлзэл ихтэй гутрал, уур, баяр хөөр ээлжилдэг.
- Идэвхтэй өөрийгөө эрэн сурвалжилдаг- “Би хэн бэ?”, “Би юу чаддаг вэ?” гэх мэт.
- Насанд хүрэгчдийн шүүмжлэлд эмзэг ханддаг.
- Шүүмжлэл, үл ойлголцлоос сэтгэлээр унах, ганцаардах мэдрэмж ихэсч болно.

Зуны амралтаар юуг сурч ирэх вэ?

Та бүхэн зуны амралтын хугацаандаа дараах зүйлсийг хийж, хүүхдэдээ дадал хэвшил болгон ирвэл сургуулийн амьдралд тустай байх болно.

- Агаарт гаргах, амин дэмтэй хоол хүнс хэрэглэх зэргээр биеийн дархлааг дэмжиж, чийрэгжүүлэх
- Нүд, шүдний үзлэгт хамруулж, шаардлагатай бол эмчилгээ хийлгүүлсэн байх
- Бусадтай нээлттэй ярилцах, бусдын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрөх хандлагад суралцуулах
- Өөрийн ирээдүйн зорилго, хүсэл мөрөөдлөө тодорхойлох, түүнд хүрэх төлөвлөгөө гаргах
- Ном унших, өдрийн тэмдэглэл хөтлөх
- Орой эрт унтаж хэвших, өдөр бүр дасгал хөдөлгөөн хийх дадалтай болох
- Гэр бүлийн гишүүн бүр нээлттэй ярилцаж, нэгнээ сонсож сурах



ДҮРЭМТ ХУВЦАС

Дээрх талуудыг харгалзан сургуулиас баталсан дүрэмт хувцсын загварыг танилцуулж байна. Дүрэмт хувцсыг 2026 оны 8 дугаар сарын сүүлээр заасан өдрүүдэд Шинэ Монгол Гурав сургууль дээрээс ирж худалдан авах боломжтой.

01 Дүрэмт хувцас ДУНД СУРГУУЛЬ

ЭРЭГТЭЙ

Үндсэн форм:

1. Цагаан цамц
2. Ногоон ноосон кардиган цамц
3. Өмд-саарал шоотой

ЭМЭГТЭЙ

Үндсэн форм:

1. Цагаан сейлор (усан цэргийн) цамц
2. Ногоон ноосон кардиган цамц
3. Юбка-саарал шоотой

02 Дүрэмт хувцас АХЛАХ СУРГУУЛЬ

ЭРЭГТЭЙ

Үндсэн форм:

1. Цагаан цамц
2. Ногоон пиджак
3. Өмд-саарал

ЭМЭГТЭЙ

Үндсэн форм:

1. Цагаанцамц
2. Ногоон пиджак
3. Юбка-саарал

Сургууль дотор сольж өмсөх сургуулийн гутал

Биеийн тамирын пүүз /хөлд хөнгөн, нимгэн ултай байх/

Охид хар, хар хөх өнгийн трико өмсөнө

03

**Биеийн тамирын хувцас
/бүх сурагчид ижилхэн/**


1. Өмд цамцны хослол
2. Цагаан футболка




Үйл ажиллагааны үнийн мэдээлэл

| № | ТӨЛБӨРИЙН ТӨРӨЛ | ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ | Тайлбар |
|----|---------------------------|---------------------|---|
| 1 | Сургалтын төлбөр | 10,500,000₮ | Анги хамаарахгүй. |
| 2 | E-school | 40,000₮ | Анги хамаарахгүй. |
| 3 | Эрүүл мэндийн даатгал | 10,000₮ - 20,000₮ | Даатгалын нөхцөлөөс шалтгаалаад үнэ тогтоно. |
| 4 | Дүрэмт хувцас | 200,000₮ – 300,000₮ | Загвар болон хэмжээнээс хамааран үнэ хэлбэлзэнэ. |
| 5 | Тамирын хувцас | 100,000₮ – 150,000₮ | Наснаас хамаарч үнийн дүн өөр байна. |
| 6 | Сургуулийн гутал | 80,000₮ – 150,000₮ | Үнийн дүн нь размераас хамааран өөр байна. |
| 7 | Хоолны төлбөр | 10,000₮ – 13,000₮ | 1 өдрийн төлбөр |
| 8 | Сүү хөтөлбөр | 1,200₮ | 1 өдрийн төлбөр |
| 9 | Ном, сурах бичгийн төлбөр | 50,000₮ - 500,000₮ | Oxford, сурах бичиг болон сургалтын материалууд |
| 10 | Амьдрах чадварын хөтөлбөр | 100,000₮ – 300,000₮ | Уг үнийн дүнд эрүүл мэндийн шинжилгээ, автобусны болон хөтөлбөрийн төлбөр багтах бөгөөд хөтөлбөрөөс хамаараад үнэ хэлбэлзэнэ. |

Нэмэлт тайлбар: Дээрх үнийн дүнд тусгагдаагүй зарим зардлууд нэмэлтээр гарах боломжтой.



**Өдрийн
ХООЛНЫ
МЭДЭЭЛЭЛ**



Эрүүл хооллолтын бодлого

Шинэ Монгол 3 сургуулийн хоолны газар нь нийт 14 хүний бүрэлдэхүүнтэйгээр Монгол улсад мөрдөгдөж буй стандарт, шаардлагыг баримтлан сурагчдын эрүүл мэнд, биеийн онцлогт тохирсон хоол хүнсийг үйлдвэрлэн үйл ажиллагаагаа явуулж байна. Мөн хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд стандарт, шаардлага хангасан орчин үеийн тоног төхөөрөмжийг ашигладаг.

Түүнчлэн цахим төлбөрийн системийг ашигладаг бөгөөд хоолны мэдээлэл нь сурагч болон эцэг эх, асран хамгаалагчдад нээлттэй байдаг давуу талтай. Сурагчдын өдрийн хоолыг уламжлалт хоол хүнсэнд тулгуурлан 7 хоног тутамд шинэчилсэн цэсийн дагуу бэлтгэдэг. Олон төрлийн тэжээллэг, чанартай хүнсний бүтээгдэхүүнийг сонгон авч, хадгалалт болон боловсруулалтын нарийн технологийг мөрдөн ажилладаг.



Өдрийн хоолны мэдээлэл

- Хичээлийн жил эхлэхэд хүүхэд бүрт өдрийн хоолны хөтөлбөрт хамрагдах бөгөөд зарлага гарах боломжтой eSchool системтэй холбогдсон төлбөрийн карт олгогдоно.
- Хоолны төлбөрийн нэхэмжлэлийг улирлаар эцэг эхийн e-PARENT аппликэйшн рүү илгээх ба эцэг эх, асран хамгаалагч өөрийн эрхээр орж төлснөөр хүүхдэд олгогдсон карт цэнэглэгдэнэ.
- Цэнэглэсэн дүнгээс ашиглаагүй дүндараагийн улиралд автоматаар шилжин ашиглагдана.
- Өдөр бүрийн сет хоолны зурган мэдээлэл эцэг эхийн аппликэйшнд мэдээлэгдэнэ.



**Хувцаслалт &
Цахим
хэрэглээний
бодлого**



Хувцаслалт

- Бүх сурагч сургууль руу орохдоо гадуур гутлаа тайлж, дотор гутлаа өмсөнө. Үүний дараа локерын хэсэгт очин гадуур хувцас, гутлаа өөрийн хувцасны шүүгээнд хийж, хөлд эвтэйхэн, чийг татахгүй, хар зураас гаргадаггүй гутал сольж өмсөнө.
- Бүх сурагч сургуулиас баталсан дүрэмт хувцсыг заавал өмсөнө. Дүрэмт хувцсыг тогтмол угааж, индүүдэн цэвэр өмсөнө. Эмэгтэй сурагчид цагаан трико өмсөнө.
- Биеийн тамир, бүжгийн хичээл, дугуйлан секцэд зориулалтын гутал хувцсыг өмсөнө.
- Нүүр, үс, хумсыг будахгүй.
- Урт үстэй хүүхдүүд үсээ бооно. Үсийг этгээд хэв маягаар засахгүй ба хичээл хийхэд саад болохуйц нүүр рүү унжуулахгүй бооно.
- Овор хэмжээтэй гоёл чимэглэл зүүхгүй.
- Гарын ариун цэврийг сахих ба хумсыг **2мм**-ээс илүү ургуулахгүй.
- Сургууль дотор гадны гутал, хувцас, малгайтай явахгүй.
- Амралтын өдрүүдээр сургуулийн гутлаа авч явж угааж цэвэрлэнэ.

Гар утас, ухаалаг төхөөрөмжийн хэрэглээ

Орчин цагийн хүмүүсийн томоохон асуудал бол цахим хэрэглээний хамаарал билээ. Дэлгэцийн хэт их хэрэглээ нь хүүхдийн нойрны чанарт 90% нөлөөлдөг гэсэн судалгаа байдаг бөгөөд анхаарал төвлөрөх хугацааг бууруулж суралцах чадварт сөргөөр нөлөөлөх, цаашлаад сэтгэл түгшил бий болгох, нийгмээс тусгаарлагдах хандлагыг нэмэгдүүлж буй.

Иймд та бид хүүхдүүдэд бага наснаас нь дэлгэцийн хамаарал үүсгэхээс сэргийлж, сургуулийн болон сургуулийн бус цагаар ухаалаг төхөөрөмжийн хэрэглээг зохистой түвшинд байлгах, нөлөөлөл багатай орчинг үүсгэх, мэдээлэл мэдлэгийг олгох, үлгэрлэн үзүүлэх зэргээр хамтран ажиллах шаардлагатай байна.

Шинэ Монгол-3 сургууль нь хичээлийн цагаар ухаалаг утас ашиглахыг хязгаарлах ба ухаалаг төхөөрөмжийг зөвхөн зорилготой, багшийн чиглүүлэг дор, богино хугацаанд ашиглана.

Бодит ертөнц дэх амьд харилцаа, ярилцлага, хамтын бүтээлч үйл ажиллагааг технологиос түрүүнд тавьж, цахим хэрэглээтэй холбоотой эрсдэл, хувийн мэдээллийн хамгаалал, ёс зүйтэй хэрэглээний талаарх анхан шатны мэдлэгийг олгож ажиллах болно.

• Гар утас ашиглах ба ашиглахгүй цаг

Хичээл, сургалтын болон хичээлээс гадуурх үйл ажиллагаанаас бусад үеэр гар утсаа ашиглахыг зөвшөөрнө. Сурагч зөвшөөрөгдөөгүй цагт гар утсаа хэрэглэсэн тохиолдолд багш тухайн цагийн туршид түр хурааж авч болно.

• Зайлшгүй холбоо барих тохиолдол

Хүүхэд гар утсаа унтраасан үеэр ар гэрээс нь холбогдох шаардлага үүссэн нөхцөлд сургуулийн дотуур утасруу холбогдоно.

• Эцэг эх, асран хамгаалагчийн үүрэг

Эцэг эх, асран хамгаалагч нь хүүхдэдээ зөвхөн өөрийнх нь нэр дээр бүртгэлтэй гар утасны дугаарыг ашиглуулна. Гэр бүлийн орчиндоо ухаалаг төхөөрөмж, цахим хэрэглээний зохих хязгаарлалтыг бий болгож, нийгмийн сүлжээ зэргийн сөрөг тал ба аюулыг үүхдэдээ сайтар зааж өгч, өөрсдөө үлгэрлэн нөлөөлөх нь чухал юм.



**Эцэг эх, асран
хамгаалагчийн
оролцоо**





Шинэ Монгол-3 сургууль нь эцэг эх, асран хамгаалагчдадаа хүүхдийнхээ сургуулийн үйл ажиллагаанд оролцож, тэднийхээ насан туршийн дурсамжид үлдэх олон талт боломжийг нээхийг зорьж байна.

Эцэг эхийн оролцооны боломжууд



- **Эцэг эхийн зөвлөл**


Сургууль нь эцэг эхийн зөвлөлтэй байх бөгөөд төрөл бүрийн үйл ажиллагаанд эцэг эхийн зөвлөлөөр дамжуулан хамтран ажиллана.

- **Эцэг эхийн туршлага хуваалцах яриа**

Төрөл бүрийн онцлог бүхий мэргэжилтэй эцэг эхчүүд сурагчдад өөрийн мэргэжлээ танилцуулах өдөрлөгт оролцох, эцэг эхчүүд багт хуваагдан, хүүхдийнхээ ангид өглөөний цагаар ном унших зэрэг сайн дурын үүрэг гүйцэтгэх боломжийг бий болгоно.

- **Хичээлтэй танилцах, нөөц бололцоогоо ашиглах**

Хүүхдийнхээ ангийн хичээлд сууж, анги дээрээ хэрхэн бусадтайгаа харилцдаг болон хичээлдээ хэрхэн оролцдогийг ажиглах боломжтой байна.



Хөршийн холбоонд суурилсан хамтын ажиллагаа

- **Сургууль нь хотхоны соёлын төв**

Сургууль нь хотхоны оршин суугчдад тодорхой хэмжээнд нээлттэй байх ба номын санг ашиглах, хотхоны оршин суугчдын өдөрлөгийг зохион байгуулахад анги танхимыг ашиглахад нээлттэй байх зэргээр хамтран ажиллана.

- **Байгаль, хүнд ээлтэй амьдралын хэв маягийн хэв маяг**

Хүрээлэн буй орчноо сайжруулах иргэн хүний оролцооны ач холбогдлыг хүүхдүүд гэр бүлээрээ практик дээр хамтдаа суралцаж, хэрэгжүүлэх боломжуудыг эрэлхийлнэ. Хоггүй хотхоныг бий болгож, хүн болгоны оролцоон дээр бий болдог байгаль орчны асуудлуудыг хамтдаа шийдвэрлэхийг зорино.





ШИНЭ  ESTD 2000
МОНГОЛ 

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ

Хүүхэд бүрийн онцгой чанарыг ургуулна.

Холбоо барих:

Мэдээлэл авах: 72990003
Санхүүгийн хэлтэс: 72990003 /5/
www.shinemongol3.edu.mn
hello@shinemongol3.edu.mn

Х а я г:

Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул
дүүрэг, 8-р хороо, Неосити хотхон